



САНТ СУМЫН АРДЧИЛСАН
НАМЫН ХОРООНД

**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040 Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

2022.07.30 № СА-2022/04-НА-30
танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Сант сумын Ардчилсан намын хорооны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох Сант сумын Ардчилсан намын хороо нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газар нь аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

018020623

Дүгнэлт

Сант сумын Ардчилсан намын хорооны Сант сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Сант сумын Ардчилсан намын хорооны мөрийн хөтөлбөр / 5... хуудас /-ийг хавсаргав.


Хувийг: Сант сумын Сонгуулийн хороонд

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНТ СУМЫН 2020 ОНЫ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
САНТ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



Сэлэнгэ аймгийн Сант сумын иргэн бүрийг хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай хууль журмыг чандлан мөрддөг сум болон хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн 2020-2024 оны орон нутгийн ИТХ-ын сонгуульд “Өрхийн өсөлт, иргэний оролцоо тогтвортой хөгжлийн үндэс” хэмээх мөрийн хөтөлбөрөө та бүхэнд танилцуулж байна.

НЭГ. ХУВЬ ХҮН, НИЙГМИЙН ХӨГЖИЛ ЭРХ ЧӨЛӨӨ

1.1 Өрсөлдөх чадвартай боловсрол

- 1.1.1 Хүүхэд бүрийг хөгжүүлж, өөртөө итгэлтэй, Монгол орныхоо байгаль, түүх үндэсний хэл соёл, уламжлалаар бахархдаг хүмүүжил олгох “Зөв Монгол хүүхэд” хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлнэ.
- 1.1.2 Сургууль, цэцэрлэгийн удирдлагыг мэргэшсэн тогтвортой, улс төрөөс хараат бус байх зарчмыг хэрэгжүүлнэ.
- 1.1.3 Сант суманд ХАА-ийн чиглэлийн их дээд сургуулийн анги, салбарыг нээж сумдын болон бүс нутагтаа хөдөө аж ахуйн болон инженер техникийн ажилтнаар хангах бодлогыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.
- 1.1.4 Иргэний боловсролыг сайжруулах чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.

1.2 Эрүүл мэндийн үйлчилгээ

- 1.2.1 Иргэдийн халдварт болон халдварт бус өвчлөл, эх болон нярайн эндэгдлийг бууруулахад анхаарч ажиллана.
- 1.2.2 Сумын эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээг түргэн шуурхай чанар хүртээмжтэй, ил тод, ёс зүйтэй, иргэддээ ээлтэй болгоно.
- 1.2.3 Иргэдийг насны бүлэгт нь тохирсон урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоонд хамруулна.
- 1.2.4 Архидалт, хар тамхи, мансууруулах бодист донтох, амиа хорлолтын шалтгаан, сэтгэл зүйн өвчлөлийг эрт илрүүлэхэд аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтарч ажиллана.
- 1.2.5 Тэтгэвэр тогтоолгосон ахмад эмч, сувилагч нарыг эрүүл мэндийн байгууллагад зөвлөхөөр ажиллуулах боломжийг бүрдүүлнэ.
- 1.2.6 Эрүүл мэндийн даатгалын цахим картыг нэвтрүүлэхэд бодлогоор дэмжиж ажиллана.
- 1.2.7 Эмийн хөнгөлөлтөд хамрагдах иргэдийн судалгааг гаргаж, үнэд тавих хяналтыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

1.3 Хүн амын өсөлт, хөгжил

- 1.3.1 Хүүхдийн хүмүүжил, төлөвшлийн асуудалд онцгой анхаарч, цэцэрлэгийн өмнөх насны хүүхдийг хүмүүжүүлэх бодлого, хүүхдийг гэр бүлийнхээ орчинд, ээж аавтайгаа хамт хүмүүжиж төлөвших хөтөлбөрийг орон нутагтаа хэрэгжүүлнэ.

- 1.3.2 Гэр бүлийн боловсрол олгох, ажил хөдөлмөр эрхлэх, санхүү, бизнесээ хөгжүүлэх, амьдрах орчноо хамтаа сайжруулах, мэдлэг ур чадварын сургалт, зөвлөмжөөр хангагдах боломжийг бодлогоор дэмжиж, хамтран ажиллана.
- 1.3.3 Суманд хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг бодлогоор дэмжинэ.
- 1.3.4 Жендерт суурилсан хүчирхийлэл, ялгаварлан гадуурхал, бэлгийн дарамтыг арилгах санал санаачилгыг дэмжиж ажиллана.

1.4 Ажлын байр, хөдөлмөр эрхлэлт

- 1.4.1 Орон нутагт гарааны бизнес буюу старт-апыг хөгжүүлэх экосистем (санхүүжилт, сургалт, мэдээлэл гэх мэт)-ийг бүрдүүлнэ.

1.5. Нийгмийн хамгаалал

- 1.5.1 Нийгмийн хамгааллын зорилтот бүлэгт чиглэсэн оновчтой бодлого хэрэгжүүлж, халамжийг шаардлагатай өрх, иргэд рүү төвлөрүүлэхэд анхаарч ажиллана.
- 1.5.2 Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлж, сайн дурын даатгуулагчдын тоог нэмэгдүүлэхэд бодлогоор дэмжинэ.
- 1.5.3 Иргэд, малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлж, тэдний нийгмийн баталгааг хангана.

ХОЁР. ХҮРТЭЭМЖТЭЙ ЭДИЙН ЗАСАГ

2.1. Хямралыг боломж, боломжийг өсөлт

- 2.1.1. Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд орон нутгийн үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг өргөнөөр ашиглах журам боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 2.1.2. Үр тариа, төмс хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүн, жимс жимсгэнэ, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүнүүдийг зах зээлд борлуулахад бодлогоор дэмжинэ.
- 2.1.3. Малын өвөлжилтөд онцгой анхаарч өвс тэжээлийн хомсдолоос сэргийлэх зорилгоор тэжээлийн нөөц бүрдүүлэхийг бодлогоор дэмжиж ажиллана.
- 2.1.4. Эрүүл мэнд, боловсролын байгууллагуудын тогтвортой ажиллагааг хангах бодлого баримтална.

2.2. Жижиг дунд бизнес, бизнесийн дархлаа

- 2.2.1. Төрийн зүгээс бизнес эрхлэгчдэд үзүүлж буй хүнд суртал, дарамтыг арилгаж, татвар төлөгч аж ахуй нэгжүүддээ үйлчилдэг, зөвлөдөг бодлого баримтална.

2.3. Төсөв, санхүү, татварын бодлого

- 2.3.1. Татварын байцаагч, иргэн, аж ахуй нэгж, байгууллагын харилцан уялдаа холбоог сайжруулах, татварын зөвлөгөө өгдөг, хуулийг дээдэлдэг, бизнесийг дэмжинэ.
- 2.3.2. Иргэн, аж ахуйн нэгжийн бизнесийн үйл ажиллагааг дэмжсэн өгөөжтэй санхүүгийн зуучлалыг хөгжүүлэх бодлого баримтална.

2.4. Хөдөлмөрийн зах зээл

- 2.4.1. Малын гаралтай түүхий эдийг боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар ажлын байрыг нэмэгдүүлнэ.
- 2.4.2. Мэргэжилтэй ажиллах хүчин, дээд боловсрол олгох их, дээд, дунд мэргэжлийн сургууль төгсөгчдийг үе шаттайгаар ажлын байраар хангах бодлого баримтална.

2.5. Үйлдвэрлэл

- 2.5.1. Хөдөө аж ахуйн боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, олон улсын чанар, стандартыг нутагшуулж, экспортлох цогц арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлнэ.
- 2.5.2. Сант суманд “Органик хүнс” хөтөлбөр боловсруулж, мах, сүү, гурил, хүнсний ногоо зэрэг бүтээгдэхүүнээр дотоод хэрэгцээг хангаж, экспортлох бодлогыг хэрэгжүүлнэ.
- 2.5.3. Малаас гарч буй түүхий эд болох арьс шир, ноос ноолуур боловсруулах үйлдвэрлэл эрхлэгчдийг бодлогоор дэмжинэ.
- 2.5.4. Үйлдвэрлэл, бизнес эрхлэгчдийг гадаадын хөрөнгө оруулалт, зээл, тусламжид хамруулах бодлого баримтална.

2.6. Дэд бүтэц, барилга

- 2.6.1. Сум, орон нутгийн нутаг дэвсгэр дээрх авто замын болон аялал жуулчлалын зориулалттай авто замын сүлжээний танилцуулга гаргана.
- 2.6.2. Гудамж, нийтийн эзэмшлийн талбай, авто замуудыг камержуулах ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.6.3. Шинэ суурьшлын бүс болон сумын төвийн шинэчлэлийн хүрээнд инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг бүрэн барьж ашиглалтад оруулах санхүүжилтийг холбогдох төсөвт тусгуулж, шийдвэрлүүлнэ.

ГУРАВ. ОРОН НУТГИЙН БҮСЧИЛСЭН ХӨГЖИЛ

3.1. Орон нутгийн хяналт

- 3.1.1. Сум орон нутгийн эдийн засгийн бие даасан байдлыг хангаж төсөв бүрдүүлэх, орлогыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулна.
- 3.1.2. Орон нутгийн төрийн худалдан авалтын үйл ажиллагааг сумандаа сонгон шалгаруулдаг, дотоодын хөрөнгө оруулагчдыг оролцуулдаг, шалгарсан байгууллагууд сум орон нутгаас ажиллах хүч авч ажиллуулах бодлого баримтална.
- 3.1.3. Орон нутгийн аж ахуйн нэгж, компаниудын чадавх, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх төслүүдийг дэмжинэ.
- 3.1.4. Мал аж ахуй, газар тариалан, гахай, тахиа, зөгий, загасны аж ахуйд суурилсан орон нутгийн онцлог шинэ брэнд бүтээгдэхүүний бизнес загварыг хөгжүүлэх бодлого баримтална.

3.2. Шинэ хөдөө хөтөлбөр

- 3.2.1. Төмс, хүнсний ногоо тариалагчдыг хүлэмж, зоориор хангах, борлуулалтыг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- 3.2.2. Сумын төвийг дахин төлөвлөж, ногоон байгууламж, дэд бүтэц, МСҮТ-ийн барилга байгууламжийг сэргээн засварлаж орчин үеийн сууринг хөгжүүлэх бодлого баримтална.
- 3.2.3. Сумын шинэчлэлийг иргэдийн оролцоотой “Шинэ сум” төслийн хүрээнд хэрэгжүүлнэ.

3.3. Бэлчээр ашиглалт

- 3.3.1. Малчдын малын гаралтай түүхий эдийг боловсруулах бодлогыг хэрэгжүүлж, дэмжинэ.
- 3.3.2. Сумын бэлчээр ашиглалтыг сайжруулах журам, бэлчээрийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлнэ.

- 3.3.3. Малчдын хамтын оролцоонд тулгуурлан бэлчээрийн тогтвортой ашиглалтыг хангаж, доройтсон бэлчээрийг сэргээх бодлого баримтална.
- 3.3.4. Малчдыг “Бэлчээр ашиглалтын холбоо”-ны зохион байгуулалтад оруулж, бэлчээрийг гэрээгээр ашиглуулах хэлбэрээр бэлчээрт малын даацыг тохируулан бэлчээрийн ургамлын сэргэх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлэх арга хэмжээ авна.
- 3.3.5. Сумын хэмжээнд ашиглагдаагүй, ашиглалт багатай бэлчээрийн нөөцийг тогтоож дэд бүтэц, худаг усны хангамжийг үе шаттай шийдвэрлэх бодлого баримтална.
- 3.3.6. Ашиглалт багатай, олон жил ашигласнаас хөрсний үржил шим муудсан болон олон жилийн судалгаагаар ургац муу өгдөг тариалангийн талбай болон бусад нөөц газраас олон наст уургийн агууламж өндөртэй тэжээлийн ургамал тариалах зориулалтаар “Бэлчээр ашиглалтын холбоо”-нд эзэмшүүлэх бодлого баримтална.
- 3.3.7. Малын тооноос чанарт шилжүүлэх бэлчээрийн даацыг тохируулан хамгаалж, сайжруулсан малчин өрх, “Бэлчээр ашиглалтын холбоо”-г дэмжиж хамтран ажиллана.

3.4. Газар тариалан

- 3.4.1. Газар тариалангийн услалтын системийг боловсронгуй болгож, гадаргуугийн усалгаа, бага оврын услалтын системийг хөгжүүлэх асуудлыг бодлогоор дэмжинэ.
- 3.4.2. Газрын үржил шимийг зохистой ашиглаж, газар тариалангийн үйлдвэрлэлд орчин үеийн технологи инновац нэвтрүүлэх арга хэмжээ авна.
- 3.4.3. Малын тэжээлийн үйлдвэрлэлийг ХААИС-ийн багш эрдэмтэдтэй хамтран хэрэгжүүлнэ.
- 3.4.4. Дөрвөн улирлын хүлэмжийн аж ахуй, төмс, хүнсний ногоо хадгалах зоорийг дэмжиж ажиллана.

3.5. Мал аж ахуй

- 3.5.1. Малыг тооноос чанарт шилжүүлж, малын төрлийг зохистой харьцаанд хүргэж, эдийн засгийн ашигтай, технологид суурилсан мал аж ахуйг бодлогоор дэмжинэ.
- 3.5.2. “Шинэ хөдөө” хөтөлбөрийн хүрээнд мах, сүү, малын гаралтай түүхий эдийг боловсруулах арга хэмжээ авна.
- 3.5.3. Мал аж ахуйн эрүүл бүсийг баталгаажуулж, мал эмнэлгийн үйлчилгээний хүртээмжийг чанартай болгож, хяналтыг сайжруулна.

ДӨРӨВ. ХАРИУЦЛАГАТАЙ САНТ

- 4.1. Иргэний эрх, эрх чөлөөг хамгаалж, хөгжлийг дэмжиж, цахимжсан нийтийн албыг бэхжүүлж, шинэчлэл хийнэ.
- 4.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхэд залуусыг гэмт хэрэгт өртөхөөс хамгаалах, үйл ажиллагааны хүртээмж үр нөлөөг нэмэгдүүлэхэд анхаарна.
- 4.3. Нас хүйс хөгжлийн ялгаа, бэлгийн чиг баримжаа гэх мэт аливаа төрлийн ялгаварлал, дарамт хүчирхийллийг гэр бүлийн орчин, ажлын байр, олон нийтийн бүх орчинд таслан зогсооход чиглэсэн үе шаттай арга хэмжээг хэрэгжүүлнэ.

- 4.4. Хүүхэд эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүл, сургуулийн орчинд хүүхдийн эрхийг ханган, ажлын байран дахь бэлгийн дарамттай тэмцэхэд иргэдийн оролцоог дэмжинэ.
- 4.5. Сумын нутгийн удирдлагын ил тод, нээлттэй байдал, шийдвэр гаргах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор ИТХ-ыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулна.
- 4.6. Иргэд гарын үсэг цуглуулж тодорхой асуудлыг хөндөж, дэвшүүлсэн тохиолдолд сумын ИТХ шууд авч хэлэлцдэг болгоно.
- 4.7. Хууль сурталчлах, таниулах ажлын чанарыг дээшлүүлж олон нийтэд хууль зүйн мэдээллийг шуурхай үр дүнтэй хүргэх бодлого баримтална.
- 4.8. Иргэддээ итгэж, анхан шатны нэгж дээрээ асуудлаа шийдвэрлүүлэх зарчимд тулгуурласан нутгийн удирдлагыг бэхжүүлнэ.
- 4.9. Орон нутагт зохион байгуулах аливаа төсөл, тендерийн сонгон шалгаруулалтыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид, олон нийтийн оролцоотой, ил тод, нээлттэй болгоно.

ТАВ. ЭКО СИСТЕМИЙН ТЭНЦВЭРТЭЙ БАЙДАЛ

- 4.10. Бэлчээрийн ургамлыг сэргээх чадавхад суурилсан менежментийг нэвтрүүлж, цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.
- 4.11. Ой, рашаан, булаг хамгаалсан өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуй нэгжийг бодлогоор дэмжинэ.
- 4.12. Ногоон орчин бий болгосон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, айл өрхийг жимс, жимсгэнэ тариалах сургалтад хамруулах ажлыг зохион байгуулна.

САНТ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН ХОРОО

